

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 24 оны 08 сарын 21 өдөр

№ R-2024-40

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн гаргасан хувьцааны тодорхой хэсгийг
эргүүлэн худалдан авч халааслах тухай

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.11 болон 36.12 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгч болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А-262/262 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журмын 1 дүгээр зүйлийн 1.2.6 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, ХасБанк ХК ("ХасБанк")-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.26 дахь хэсгийг тус тус үндэслэн дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанкны олон нийтэд санал болгож гаргасан хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл дараах саналыг дэмжсэн болохыг тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. ХасБанкны гаргасан хувьцааны тодорхой хэсгийг энэхүү тогтоолын хавсралтад заасан байдлаар эргүүлэн худалдан авч халаасласугай.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Хувьцаа эргүүлэн худалдан авах ажлыг гүйцэтгэх, зохицуулагч байгууллагаас зохих зөвшөөрөл авах, харилцах зэрэг энэ ажлыг зохион байгуулахтай холбоотойгоор шаардлагатай, эсхүл зохистой гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгаж, холбогдох эрхийг олгосугай.
3. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанкны ТУЗ-ийн 2024 оны 8-дугаар сарын 21-ний өдрийн
R-2024-40 дүгээр тогтоолын Хавсралт



ХАСБАНК ХК-ИЙН ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОДОРХОЙ ХЭСГИЙГ ЭРГҮҮЛЭН
ХУДАЛДАН АВАХ НӨХЦӨЛ

1	Эргүүлэн худалдан авах хувьцааны тоо	2,300,000 ширхэг
2	Эргүүлэн худалдан авах хувьцааны үнэ	760 төгрөг хүртэл
3	Эргүүлэн худалдан авах хувьцааны нийт үнийн дүн	1,748,000,000 төгрөг хүртэл
4	Эргүүлэн худалдан авах хугацаа	3 сар хүртэл